



# МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-ИЙН  
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/10/СТА-ТӨҮГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

2018 он

**Аудитын код: САГ-2018/10/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Аудитор Д.Цэгмиддорж  
Утас: 261740 Цахим хаяг: [tsegmiddorjd@audit.gov.mn](mailto:tsegmiddorjd@audit.gov.mn)

Конфиденсе Аудит ХХК  
Багийн ахлагч: П.Ариунаа  
Утас:99994990, 322431, факс:70139100  
Аудитын менежер: М.Ундрах  
Ахлах аудитор: Ж.Ариунбаатар  
Аудитор: Г.Шинэцэцэг

Хаяг: Чингэлтэй дүүрэг, Жуулчны гудамж, Капитал центр, 1005 тоот

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	0
2	Аудитын тайлан .....	1
2.1	Оршил .....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн 3	
2.5	Дотоод хяналт .....	3
2.6	Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	6
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	6
2.9.1	Хувьцааны бүртгэлийн талаар.....	6
2.9.2	“ТТJVCO” ХХК-тай холбоотой өглөгийн бүртгэлийн талаар .....	6
2.9.3	“Хишиг арвин индустриал” ХХК-тай холбоотой өглөгийн бүртгэлийн талаар .....	7
2.9.5	Урт хугацаат өр төлбөрийн талаар .....	7
2.9.6	Маргаантай өглөгийн бүртгэлийн талаар .....	7
2.9.7	Хувьцааны бүртгэлийн талаар.....	7
2.9.8	Хөрс хуулалтын хөрөнгө ба түүний хорогдуулалтын талаар.....	8
2.9.9	Нөхөн сэргээлт-хаалтын хөрөнгө ба түүний хорогдуулалтын талаар.....	8
2.9.10	Нүүрсний овоолгын бүртгэл, үлдэгдлийн талаар .....	8
2.9.11	Уурхайн үйл ажиллагаанд ашигладаг Minex, Micromine програмын хорогдуулалтын талаар .....	9
2.9.12	Маргаантай өглөгийн бүртгэлийн талаар .....	9
2.9.13	Ашиглагдахгүй байгаа, ашиглалт муутай хөрөнгийн бүртгэлийн талаар ..	9
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	10
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: .....	10
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Хувьцааны бүртгэлийн талаар .....	13
3.2	Хөрс хуулалтын хөрөнгө ба түүний хорогдуулалтын талаар .....	14
3.3	Нөхөн сэргээлт-хаалтын хөрөнгө ба түүний хорогдуулалтын талаар .....	15



3.4	Уурхайн үйл ажиллагаанд ашигладаг Minex, Micromine програмын хорогдуулалтын талаар .....	16
3.5	Нүүрсний овоолгын бүртгэл, үлдэгдлийн талаар .....	17
3.6	Маргаантай өглөгийн бүртгэлийн талаар .....	19
3.7	Ашиглагдахгүй байгаа, ашиглалт муутай хөрөнгийн бүртгэлийн талаар .....	20
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	21
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	21
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	22
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	23
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	24



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

"ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ"  
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.АРИУНБОЛД ТАНАА

2018.03.14 № 06/664  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эрдэнэс таван толгой" ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол "Эрдэнэс таван толгой" ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Эрдэнэс таван толгой" ХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2018\03\155AG89 Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## Аудитын гол асуудал

### 1. Хувьцааны бүртгэлийн талаар

"Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын 8.2-ыг үндэслэн, "Эрдэнэс монгол" ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн удирдамж, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тушаалыг үндэслэн компани хувьцаагаа бүртгэсэн.

Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын 8.2-т нэгж хувьцааг 933 төгрөгөөр үнэлж, нийт 11,196,000.0 сая төгрөгөөр бүртгэхийг заасан байна. Бид нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 933 төгрөг байна гэсэн анхны тооцоолол, түүнийг нотлох баримтыг олж авч чадаагүй.

### 2. Нүүрсний овоолгын бүртгэл, үлдэгдлийн талаар

Нүүрсийг олборлогч нараас авахдаа куб.метрээр тооцоолж авдаг, бүртгэлд тусгахдаа тоннд шилжүүлдэг. Худалдан авагч нарт зарахдаа тонноор хэмждэг. Сар бүрийн үлдэгдлийг маркшэйдрийн куб.метр суурилж тооцсон хэмжилтээр авдаг. Үүнээс үүдэн нягтлан бодох бүртгэл дэх нүүрсний үлдэгдэл болон маркшэйдрийн хэмжилтээрх үлдэгдлийн хооронд зөрүү үүсдэг байна. Нүүрсний овоолго дуусах бүрд дээрх зөрүүг тогтоон акт үйлдэж, үүссэн зөрүүг дараагийн сарын уулын ажлын тайландаа оруулдаг байна. Энэ нь тухайн овоолго хаагдсан сарын хөрс хуулалтын хэмжээ болон үнийн дүнг бууруулж бодит тоон мэдээлэлд нөлөө орж байна. 2017 онд нийт 32 овоолго нээгдээд хаагдсан зөрүү нь 239.4 мянган тонн. 2017 онд нээгдээд 2018 оны 3 дугаар сарын 01-ний байдлаар хаагдсан овоолго 7, зөрүү нь 90.8 мянган тонн, 2017 онд нээгдээд 2018 оны 3 дугаар сарын 01-ний байдлаар хаагдаагүй байгаа овоолго 14, зөрүү нь ойролцоогоор 139.6 мянган тонн байна.

### 3. Нөхөн сэргээлтийн нөөц (Өмнөх аудитаар илэрсэн шийдэгдээгүй байгаа)

НББОУС 37 болон тус компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод уурхайн нөхөн сэргээлтийн нөөцийг тооцоолохдоо ирээдүйд гарч болзошгүй зардлыг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлж бүртгэхээр заасан боловч борлуулалтын орлогоос 1 хувиар тооцож 2016 онд 4,671.2 сая, 2017 онд 11,823.6 сая төгрөгийн нөөцийг бүртгэсэн байна.

### 4. Нөхөн сэргээлтийн хөрөнгө (Өмнөх аудитаар илэрсэн шийдэгдээгүй байгаа)

Нөхөн сэргээлтийн хөрөнгийн тайлант оны эхний үлдэгдэл 17,169.1 сая төгрөг нэмж 11,823.6 сая төгрөг бүртгэсэн бөгөөд 980.6 сая төгрөгөөр хорогдуулалт тооцсон байна. Компани нөхөн сэргээлтийн хөрөнгийг хорогдуулахдаа лицензийн хугацаа буюу 40 жил болон 20 жилийн хугацаагаар хорогдуулж байна. НББ-д тусгасны дагуу шавхагдлаар тус хорогдуулалт байгуулахаар тусгасан байна. Иймд хорогдуулж буй үнийн дүнгийн хорогдуулалтын суурь болон хорогдол тооцох дүн нь алдаатай байна.

### 5. Үндсэн хөрөнгө (Өмнөх аудитаар илэрсэн шийдэгдээгүй байгаа)

"Цагаан хад дахь гаалийн талбай" байршилд бүртгэлтэй 5,328.9 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө нь компанид үр өгөөж өгөхгүй байна. Компани нь уурхайн амнаас нүүрс борлуулж эхэлснээр хөрөнгүүдийг ашиглахаа больсон. Компанийн удирдлага эдгээр хөрөнгүүдийг цаашид ашиглах эсэх, худалдан борлуулах эсэх талаар ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.

Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэлгээ ба хэмжилт, толилуулга ба илчлэл тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

## Үүрэг, хариуцлага

“Эрдэнэс таван толгой” ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Эрдэнэс таван толгой” ХК-ний гүйцэтгэх захирал Д.Ариунболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд тайлант үед олборлосон нүүрсний өртгийн бүртгэлд нөлөөлж байгаа биет бус хөрөнгийн хорогдуулалтыг зөв тооцоолж бүртгэх, нүүрсний овоолгын хэмжилтийг зөв тооцоолж бүртгэх, маргаантай байгаа өглөгийг эцэслэн шийдвэрлэх, ашиглагдахгүй байгаа, ашиглалт муутай хөрөнгийг зарж борлуулах асуудлыг яаралтай шийдвэрлэх талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.





“Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 29-нөөс 2018 оны 3 дугаар сарын 16-ны хооронд хийхээр төлөвлөн “Конфиденсе Аудит” ХХК-ийн Багийн ахлагч П.Ариунаа, Аудитын менежер М.Ундрах, Ахлах аудитор Ж.Ариунбаатар, Аудитор Г.Шинэцэцэг нар хэрэгжүүлж ажиллав.

“Эрдэнэс таван толгой” ХК-ний 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 02/545 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

“Эрдэнэс таван толгой” ХК санхүүгийн үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах стратегийн ач холболдол бүхий Таван толгойн нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулахад чиглэгдэнэ.

Ашигт Малтмал, Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газраас тус компанид хуульд заасан нөхцөл шаардлагын дагуу ашигт малтмал ашиглах дараах тусгай зөвшөөрлүүдийг 30 жилийн хугацаатай олгосон байна. Үүнд:

- Шар тээг /Зүүн Цанхи/ нэртэй газар орших 700.39 гектар талбайг 2006. 08.29-нд,
- Бор тээг-1 /Баруун Цанхи/ нэртэй газар орших 556.72 гектар талбайг 2006.08.29-нд,
- Таван толгой-1 /Баруун Цанхи/ нэртэй газар орших 2,447.13 гектар талбайг 2006.08.29-нд,
- Таван толгой нэртэй газар орших 2,037 гектар талбайг 2008.05.28-нд,
- Бор толгой нэртэй газар орших 12,871 гектар талбайг 2008.05.28-нд,
- Бор тээг-1 /Баруун Цанхи/ нэртэй газар орших 23,479 гектар талбайг 2008.05.28-нд,
- Шар тээг /Зүүн Цанхи/ нэртэй газар орших 24,532 гектар талбайг 2008.05.28-нд,
- Таван толгой нэртэй газар орших 5,603 гектар талбайг 2008.05.28-нд тус тус олгожээ.

Албан ёсоор батлагдсан Техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-д “Эрдэнэс таван толгой” ХК-ийн эзэмшиж буй Зүүн Цанхийн уурхай нь 750.0 сая тонн, Баруун Цанхийн уурхай нь 814.0 сая тонн нүүрсний нөөцтэй гэж тусгажээ. Үүнээс ашиглалтын хугацаанд Зүүн Цанхийн уурхайгаас 410.0 сая, Баруун Цанхийн уурхайгаас 543.0 сая тонн нүүрс олборлохоор тооцжээ. Жилийн нүүрс олборлолтын хэмжээг нь Зүүн Цанхийн уурхайгаас 15.0 сая тонн, Баруун Цанхийн уурхайгаас 20.0 сая тонн байхаар ТЭЗҮ-д тусгасан байна.



Олборлолт, борлуулалтын хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

Он	Олборлолт /мянган тонн/	Экспорт /мянган тонн/	Борлуулалтын орлого /тэрбум төгрөг/
2011	902.2	208.8	-
2012	1,816.8	1,617.5	208.7
2013	5,806.0	2,046.5	156.7
2014	6,898.7	5,736.6	400.7
2015	3,845.6	3,128.9	238.3
2016	7,725.9	7,485.1	467.1
2017	10,102.3	8,389.9	1,182.3

Компанийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

#### 2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Эрдэнэс таван толгой” ХК-ний 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс “Эрдэнэс таван толгой” ХК-ний удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 62 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/


Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 0.5 хувиар тооцож 3,271.6 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Би Ти солюшн” ХХК-ийн “Силикон 2.0, Силикон 3.0” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дотоод хяналтын нэгж нь 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2017 оны батлагдсан ажлын төлөвлөгөө, удирдамжийн дагуу Захиргааны хэлтэс, Мэдээлэл технологийн нэгж, Сургалт судалгаа хүний нөөцийн алба, Орон нутаг хамтын ажиллагааны



хэлтэс, Худалдан авалт ханган нийлүүлэлтийн газар, Ачилт экспортын алба, Засвар механикийн хэлтэс, ХАБЭАБО-ны хэлтэс, Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс, “Монруд” ХХК болон Эрчим сүлжээ харуул хамгаалалтын алба зэрэг нийт 10 газар, хэлтэст дотоод хяналт явуулж үр дүнг нэгжийн дарга болон гүйцэтгэх удирдлагад танилцуулан үйл ажиллагааг сайжруулах, илэрсэн алдаа, зөрчлийг арилгах зөвлөмж болон хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. Энэ нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой журам, дүрэм нийцлийн шалгалтууд байсан бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд чиглэсэн хяналт хийгдээгүй байна.

## 2.6 Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны үйл ажиллагааны үр дүнг төсөвтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд: Борлуулалтын орлого 55,746.3 сая төгрөг буюу 5%-иар дутуу, борлуулалтын хэмжээ 4.7 сая тонн буюу 36%-иар дутуу, үйлдвэрлэлийн зардал 64,148.8 сая төгрөг буюу 11%-ийн хэмнэлттэй, татвар хураамжийн зардал 12,456.3 сая төгрөг буюу 5%-ийн хэмнэлттэй, санхүүгийн зардал 3,342.5 сая төгрөг буюу 9%-ийн хэтрэлттэй, ерөнхий болон удирдлагын зардал 963.9 сая төгрөг буюу 13%-ийн хэмнэлттэй, маркетинг борлуулалт ложистикийн зардал 10,417.9 сая төгрөг буюу 36%-ийн хэмнэлттэй байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлбэл:


### 2017 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн хувь
	мянган төгрөг	мянган төгрөг	
<b>ЦАНХИЙН ЗҮҮН УУРХАЙ</b>	<b>684,182,250.0</b>	<b>673,562,168.0</b>	<b>-2%</b>
Исэлдсэн, эрчим хүчний нүүрс	40,972,500.0	28,027,743.8	-32%
Коксжих нүүрс	643,209,750.0	645,534,424.2	0%
<b>ЦАНХИЙН БАРУУН УУРХАЙ</b>	<b>553,927,500.0</b>	<b>508,801,306.6</b>	<b>-8%</b>
Исэлдсэн, эрчим хүчний нүүрс	43,425,000.0	10,761,098.4	-75%
Коксжих нүүрс	510,502,500.0	498,040,208.2	-2%
<b>НИЙТ</b>	<b>1,238,109,750.0</b>	<b>1,182,363,474.7</b>	<b>-5%</b>
Зүүн цанхи	684,182,250.0	673,562,168.0	-2%
Баруун цанхи	553,927,500.0	508,801,306.6	-8%

### 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Үндсэн үйл ажиллагааны зардал	Төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт (-), Хэтрэлт (+)	
	мянган төгрөг	мянган төгрөг	Төгрөгөөр	Хувиар
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>890,227,053.0</b>	<b>804,464,456.0</b>	<b>(85,762,597.0)</b>	<b>-10%</b>
<b>Үйлдвэрлэлийн зардал</b>	<b>562,546,053.2</b>	<b>498,397,251.8</b>	<b>(64,148,801.4)</b>	<b>-11%</b>
Гэрээт олборлогчийн зардал	539,633,426.9	482,326,119.1	(57,307,307.8)	-11%
Цалингийн зардал	7,300,332.1	6,927,624.3	(372,707.8)	-5%
Шатах, тослох материалын зардал	2,175,756.7	833,899.9	(1,341,856.8)	-62%
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	1,110,602.6	162,137.8	(948,464.8)	-85%
Даатгалын зардал	120,806.2	45,188.1	(75,618.0)	-63%
Сургалт хурал зөвлөгөөний зардал	154,640.0	28,555.0	(126,085.0)	-82%
Томилолтын зардал	145,198.5	123,582.5	(21,666.0)	-15%
Харилцаа, холбоо, шуудангийн зардал	121,780.0	70,565.6	(51,214.4)	-42%
Ашиглалтын зардал	480,925.1	479,956.3	(968.8)	0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	4,410,145.0	2,864,379.9	(1,545,765.2)	-35%

Урсгал засвар үйлчилгээний зардал	45,000.0	98,038.6	53,038.6	118%
Материалын зардал	143,653.3	216,846.0	73,192.8	51%
Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зардал	1,010,024.5	317,823.3	(692,201.2)	-69%
Байгаль орчныг хамгаалах задал	103,360.0	5,817.3	(97,542.7)	-94%
Элэгдлийн зардал	4,577,056.4	2,721,510.1	(1,855,546.3)	-41%
Магадалшгүй ажлын зардал	554,900.0	319,876.3	(235,023.7)	-42%
Судалгаа хөгжүүлэлтийн зардал	-	368,400.4	368,400.4	
Хураамжийн зардал	458,445.9	486,981.3	28,535.4	6%
<b>Татвар хураамжийн зардал</b>	<b>249,517,071.2</b>	<b>237,060,782.5</b>	<b>(12,456,288.6)</b>	<b>-5%</b>
АМНАТ	104,026,515.3	125,018,494.6	20,991,979.3	20%
Гаалийн хураамж	17,287,807.3	12,855,804.1	(4,432,003.3)	-26%
Агаарын бохирдлын төлбөр	13,250,000.0	10,108,891.1	(3,141,108.9)	-24%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	25,101.3	25,843.7	742.4	3%
Газрын төлбөр	239,435.7	238,255.7	(1,180.0)	0%
Ус ашигласны төлбөр	199,722.6	224,518.2	24,795.6	12%
АТӨЯХ	5,468.0	4,697.0	(771.1)	-14%
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хураамж	496,417.7	-	(496,417.7)	-100%
Давхар татвар	607,234.5	4,703,249.4	4,096,014.9	675%
НӨАТ	18,462,403.6	518,593.3	(17,943,810.3)	-97%
ААНОАТ	94,916,965.1	83,362,435.5	(11,554,529.6)	-12%
<b>Санхүүгийн зардал</b>	<b>36,178,672.7</b>	<b>39,521,255.7</b>	<b>3,342,583.0</b>	<b>9%</b>
Чалко компанийн хүүгийн зардал	3,036,172.7	4,104,142.3	1,067,969.6	35%
Хөгжлийн банкны хүүгийн зардал	33,142,500.0	35,417,113.4	2,274,613.4	7%
<b>Зөвлөх үйлчилгээний зардал</b>	<b>1,118,220.0</b>	<b>-</b>	<b>(1,118,220.0)</b>	<b>-100%</b>
Хуулийн зөвлөх үйлчилгээ	800,000.0	-	(800,000.0)	-100%
Санхүүгийн зөвлөх үйлчилгээ	318,220.0	-	(318,220.0)	-100%
<b>Удирдлагын төлбөр</b>	<b>4,426,093.6</b>	<b>4,426,093.6</b>	<b>(0.0)</b>	<b>0%</b>
"Эрдэнэс Монгол" ХХК удирдлагын төлбөр	4,426,093.6	4,426,093.6	(0.0)	0%
<b>Ерөнхий болон удирдлагын үйл ажиллагааны зардал</b>	<b>7,311,468.1</b>	<b>6,347,554.0</b>	<b>(963,914.1)</b>	<b>-13%</b>
Цалингийн зардал	4,047,045.7	4,185,054.6	138,008.8	3%
Шатахуун, тос тосол, сэлбэг хэрэгслийн зардал	142,636.9	68,163.0	(74,473.9)	-52%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	360,066.5	277,717.0	(82,349.4)	-23%
ТУЗ	622,949.0	272,639.5	(350,309.5)	-56%
Сургалтын зардал	145,950.0	43,032.3	(102,917.7)	-71%
Шуудан холбооны зардал	90,420.0	68,116.0	(22,304.0)	-25%
Томилолтын зардал	166,335.0	81,356.6	(84,978.4)	-51%
Элэгдлийн зардал	325,531.2	280,714.2	(44,817.0)	-14%
Урсгал засвар үйлчилгээний зардал	93,000.0	38,452.8	(54,547.2)	-59%
Материалын зардал	144,579.1	115,520.3	(29,058.8)	-20%
Ашиглалтын зардал	545,600.0	441,738.8	(103,861.2)	-19%
Албан татварын зардал	10,101.7	38,687.2	28,585.4	283%
Бусад зардал	40,717.8	92,491.6	51,773.8	127%
Даатгалын зардал	56,596.8	12,885.2	(43,711.6)	-77%
Авилгалын эсрэг зардал	7,500.0	(7,500.0)		100%
Уулзалт, Хурал зөвлөгөөний зардал	62,438.4	23,861.2	(38,577.2)	-61%
Бусад	450,000.0	307,123.7	(142,876.3)	-32%



<b>Маркетинг борлуулалт ложистикийн зардал</b>	<b>29,129,474.2</b>	<b>18,711,518.4</b>	<b>(10,417,955.8)</b>	<b>-36%</b>
Нүүрс ачилтын зардал	23,081,250.0	13,998,537.8	(9,082,712.2)	-39%
Маркетинг сурталчилгааны зардал	1,187,550.0	661,339.7	(526,210.3)	-44%
Борлуулалтын зардал	4,860,674.2	4,051,640.9	(809,033.3)	-17%

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 онд Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан байна. Тайлант онд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьд цахим санд 7 төрлийн мэдээллийг жил, улирал, сарын давтамжтай, 61 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Компанийн www.erdenestt.mn цахим хуудсанд шилэн дансны цэс байршуулсан бөгөөд Төсөв гүйцэтгэл, Хөрөнгө оруулалт, Тендер, худалдан авалт, Үнэт цаас, Байгууллага, Бусад гэсэн 6 дэд цэстэй байна.

Шилэн дансанд тавигдсан мэдээлэлд:

- Улирал бүрийн санхүүгийн тайлан, 7 хоног бүрийн 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын гүйлгээний жагсаалтын мэдээлэл
- Бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө
- 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг
- 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг
- Хөрөнгө оруулалтын нэгдсэн төсөв
- Тендерийн урилгыг зарладаг, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлтийн мэдээлэл
- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийн жагсаалтад сонгосон болон татгалзсан хуулийн заалтуудыг тус тус оруулжээ.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 66 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 62 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Хувьцааны бүртгэлийн талаар

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тушаалыг үндэслэн компани хувьцаагаа бүртгэсэн байна. Хувьцааны бүртгэлийг хийснээс шалтгаалан хуучин дүрмийн санг залруулах шаардлага үүсч байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд холбогдох залруулгыг хийв.

### 2.9.2 “ТТJVCO” ХХК-тай холбоотой өглөгийн бүртгэлийн талаар

2015 онд “ТТJVCO” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу уулын ажлыг нэг метр кубыг нь 2016 онд 4.389 ам.доллараар, 2017 онд 4.796 ам.доллараар үнэлэхээр тусгагдсан байсан. “Эрдэнэс таван толгой” ХК нь 2016 онд мөрдөж байсан үнийг нэмэгдүүлэхгүй гэсэн байр суурьтай байсан боловч гэрээнд тусгагдсан үнийн дүнгээрээ бүртгэлээ хөтөлж байсан байна. Аудит хийгдэж байх үеэр “ТТJVCO” ХХК-тай тохиролцоонд хүрч чадсан ба үнийг нэмэгдүүлэхгүй байхаар гэрээнд гарын үсэг

зурагдсан. Үүнээс шалтгаалан 30,000.0 орчим сая төгрөгөөр бүртгэлдээ залруулга хийх шаардлага гарч байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд холбогдох залруулгыг хийв.

### **2.9.3 “Хишиг арвин индустриал” ХХК-тай холбоотой өглөгийн бүртгэлийн талаар**

“Эрдэнэс таван толгой” ХК нь “Хишиг арвин индустриал” ХХК-аар 2013 оны 9,10,11,12 сарууд, 2014 оны 1,2,3 саруудад ачилтаа хийлгэсэн энэ хугацааны үнийг тохирч чадахгүй шүүхэд хандсан байна. Монгол Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн тогтоолоор “Хишиг арвин индустриал” ХХК-д 4,548.4 сая төгрөг төлөхөөр шийдвэрлэжээ.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд холбогдох залруулгыг хийв.

### **2.9.4 Урьдчилж төлсөн зардал**

Чалко-той байгуулсан гэрээний 4.4.7-д заасны дагуу 2.0 сая ам.долларыг “Худалдан авах зорилтот хэрэглэгчдэд нүүрс худалдах дэд бүтэц, ложистикийг БНХАУ-д бий болгох”-д зориулж Чалко-д төлсөн бөгөөд энэхүү буцаан төлөгдөх эсэх тодорхойгүй зардлыг компани зардалд бүртгээгүй урьдчилж төлсөн зардалд бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд холбогдох залруулгыг хийв.

### **2.9.5 Урт хугацаат өр төлбөрийн талаар**

Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн өглөгийн 2018 оны 3 дугаар сард төлөгдөх хэсгийг богино хугацаат өглөг дансанд бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд холбогдох залруулгыг хийв.

### **2.9.6 Маргаантай өглөгийн бүртгэлийн талаар**

Чанаргүй нүүрс нийлүүлсэн тул хохирлоо барагдуулах талаар “Улаатын дунд хошуу Илион ресурс” ХХК шүүхэд хандсан. Шүүхийн шийдвэрээр 48.8 сая төгрөгийг “Эрдэнэс таван толгой” ХК нь төлөхөөр гарсан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд холбогдох залруулгыг хийв.

### **2.9.7 Хувьцааны бүртгэлийн талаар**

““Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын 8.2-ыг үндэслэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн удирдамж, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тушаалыг үндэслэн компани хувьцаагаа бүртгэсэн.

Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын 8.2-т нэгж хувьцааг 933 төгрөгөөр үнэлж, нийт 11,196,000.0 сая төгрөгөөр бүртгэхийг заасан байна. Бид нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 933 төгрөг байна гэдгийг анхны тооцоолол, түүнийг нотлох баримтыг олж авч чадаагүй.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар дээрх асуудлын талаар зөвлөмж хүргүүлэв.

## 2.9.8 Хөрс хуулалтын хөрөнгө ба түүний хорогдуулалтын талаар

Тайлант үед олборлосон нүүрсний тоон хэмжээг ТЭЗҮ дэх тухайн үеийн ашиглалтын үе дэх хөрс хуулалтын коэффициентээр үржиж тайлант үеийн өртөгт шингэх хөрс хуулалтын тоон хэмжээг гаргадаг. Зарим сард хөрс хуулалтын бодит хэмжээ тооцоолсон хэмжээнээс илүү гардаг. Энэ тохиолдолд илүү гарсан хэмжээг тайлант үеийн нэгжийн өртгөөр үржиж хөрс хуулалтын хөрөнгийг үүсгэдэг. Зарим сард хөрс хуулалт нь тооцоологдсон буюу хэмжээндээ хүрдэггүй байна. Энэ тохиолдолд тооцоолсон хэмжээнд хүртэл хөрс хуулалтын хэмжээг нэмэгдүүлж авдаггүй байна.

- Хөрс хуулалт тооцоолол их бага гарснаас үл хамааран хуримтлагдсан хөрс хуулалтын хөрөнгийг элэгдүүлж олборлосон нүүрсний өртөгт шингээдэг.
- Хөрс хуулалтын хөрөнгө данс нь мөнгөн дүнгээрээ л санхүүгийн програмд бүртгэгдэж байна. Хөрс хуулалт дансыг биет хэлбэрээр буюу куб.метр-ээр, мөн ашиглалтын үеэр ангилан бүртгэгдэггүй байна.
- Хөрс хуулалтын хөрөнгө болон түүний хөдөлгөөн үлдэгдлийн тайланд уулын хэлтэс ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээдэггүй зөвхөн нягтлан бодогч эхсэл дээр суурилсан тооцоон дээрээ үндэслэн бичилт хийдэг.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар дээрх асуудлын талаар зөвлөмж хүргүүлэв.

## 2.9.9 Нөхөн сэргээлт-хаалтын хөрөнгө ба түүний хорогдуулалтын талаар

Нөхөн сэргээлт-хаалтын хөрөнгө данс нь борлуулалтын нэг хувиар жил бүр нэмэгдэж бүртгэгддэг. Энэ дансыг нэмэгдүүлж байгаа дүнгийн суурь тооцооллыг өмнөх аудитын компаниуд үнэн зөв гэж үзэх үндэслэл муутай гэж үзсэн ба энэ утгаараа аудиторын дүгнэлтийг хязгаарлах нэг үндэслэл болгож байсан байна. Бид бүхэн мөн энэ тооцооллыг үнэн зөв гэж үзэхгүй байгаа болно.

Энэ дансны хорогдуулалтыг тооцоолохдоо: Жил бүрийн орлогоор нэмэгдэж байгаа дүнг цанхийн уурхайн цаашид ажиллахаар төлөвлөгдөж байгаа жилд хувааж хорогдуулж байна. Энэ тооцооллоор хорогдуулбал дараагийн жилүүдэд энэ хөрөнгийн хорогдуулах дүн ихэссээр маш их болохоор тооцоологдож байна. Үүнээс шалтгаалан энэ тооцооллыг бид мөн л үнэн зөв гэж үзэхгүй байна. Өөрөөр хэлбэл тайлант жилүүдэд эсвэл олборлолтын тонн тутамд жигд хуваарилагдахгүй байна гэж үзэж байна.

Энэ нь НББОУС 37: Болзошгүй өр төлбөр ба Болзошгүй Хөрөнгө-д заасан заалтуудтай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар дээрх асуудлын талаар зөвлөмж хүргүүлэв.

## 2.9.10 Нүүрсний овоолгын бүртгэл, үлдэгдлийн талаар

- Бараа материал хариуцсан нягтлан бодогч нүүрсний ачилтыг харилцагч бүрээр сард нэг удаа бичилт хийж санхүүгийн програмд оруулдаг. Энэ нь хэтэрхий хураангуйлсан шинжтэй байна. Нүүрсний ачилтыг ачааны машинд ачилт хийгдэх бүрдээ санхүүгийн програмд бүртгэх шаардлагатай байна. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
- Нүүрсний ачилтын бичилт хийгдэх бүрд худалдан авагчаас авах авлага нэмэгдэх буюу урьдчилж төлсөн төлбөр нь буурах бичилт програмаас хийгддэг байхаар

бүртгэлийн үйл ажиллагаагаа зохицуулаагүй буюу борлуулалтын нягтлан бодогч борлуулалтын авлагыг журналаар хийж байна.

- Нүүрсийг бүртгэлд зүүний исэлдсэн болон коксожсон, барууны исэлдсэн болон коксожсон гэсэн дөрвөн ангиллаар бүртгэсэн байна. Харин уурхай дээр нүүрсийг баруун, зүүн цанхиар нь хуваахын зэрэгцээ овоолгоор бүртгэж байна. Бүртгэл ч мөн үүнтэй адил овоолгоор бүртгэх шаардлагатай байна.
- Нүүрсийг олборлогч нараас авахдаа куб.метрээр тооцоолж авдаг, бүртгэлд тусгахдаа тоннд шилжүүдэг. Худалдан авагч нарт зарахдаа тонноор хэмждэг. Сар бүрийн үлдэгдлийг маркшэйдрийн хэмжилтээр авдаг. Маркшэйдрийн хэмжилт нь куб.метрт суурилдаг. Үүнээс харахад нягтлан бодох бүртгэл дэх нүүрсний үлдэгдэлд тооллогын, үлдэгдлийн зөрүү бага боловч дүнгээр байнга гарахаар харагдаж байна. Гэтэл бүртгэлд ийм залруулга байхгүй байна. Маркшэйдүүдтэй уулзаж асуухад овоолго дуусах бүрд дээрх зөрүү гардаг энэ тохиолдолд акт үйлдэж үлдэгдлийн зөрүүг тодорхойлдог. Зөрүүгээ дараагийн сарын уулын ажлын тайландаа оруулдаг гэж тайлбарлаж байна. Энэ тохиолдолд тухайн овоолго хаагдсан сарын хөрс хуулалтын хэмжээ, үүнийг дагаад үнийн дүн буурч бодит тоон мэдээлэлд нөлөө орж байна. 2017 онд нийт 32 овоолго нээгдээд хаагдсан зөрүү нь 239,406 тонн. 2017 онд нээгдээд 2018 оны 3 дугаар сарын 01-ний байдлаар хаагдсан овоолго 7, зөрүү нь 90,825 тонн, 2017 онд нээгдээд 2018 оны 3 дугаар сарын 01-ний байдлаар хаагдаагүй байгаа овоолго 14, зөрүү нь ойролцоогоор 139,583 тонн байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар дээрх асуудлын талаар зөвлөмж хүргүүлэв.

### **2.9.11 Уурхайн үйл ажиллагаанд ашигладаг Minex, Micromine програмын хорогдуулалтын талаар**

2017 онд Minex програмыг уурхайн үйл ажиллагаанд ашиглахаар 1,050.0 сая төгрөгөөр худалдан авсан байна. Тус програмыг 3 жил ашиглана гэж Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.6.7-д тусгасаны дагуу хорогдуулж бүртгэсэн. Энэ нь хэт богино хугацаа гэж үзэж байна. Мөн Micromine програмыг 2014 онд авсан ба одоог хүртэл ашиглаж байгаа.

Энэ нь НББОУС 38: Биет бус хөрөнгө-д заасан 98-р заалттай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар дээрх асуудлын талаар зөвлөмж хүргүүлэв.


### **2.9.12 Маргаантай өглөгийн бүртгэлийн талаар**

“Говь повер” ХХК-тай холбоотой асуудал шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. “Говь повер” ХХК-иас хүлээн авсан зарим хөрөнгийг компани ашиглаж байгаа, заримыг нь акталж устгасан, зарим нь ашиглагдах боломжгүйгээр эвдэрсэн байдалтай байна. Одоогийн байдлаар газар эзэмших эрх болон байгууламжууд нь ашиглагдаагүй байна. Анхан шатны шүүхээр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн талд гарсан байна. Дараагийн шатны шүүхээс нөгөө талд шүүхийн шийдвэр гарч шүүгдэгч суллагдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар дээрх асуудлын талаар зөвлөмж хүргүүлэв.

### **2.9.13 Ашиглагдахгүй байгаа, ашиглалт муутай хөрөнгийн бүртгэлийн талаар**

- TAS 3600 маркийн 10 ширхэг авто машин ашиглагдахгүй байгаа боловч тухайн хөрөнгийг элэгдүүлж өртгийг нэмэгдүүлсэн, дахин үнэлгээ хийлгэсэн байна.





- Ашиглагдахгүй байгаа Magna маркийн 26 дугуй нийт 3,186.3 сая, Махат маркийн 18 дугуй нийт 225.3 сая, нийт 3,411.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан анхны өртгөөрөө балансад эргэлтийн хөрөнгөөр бүртгэгдсэн байна. 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн “Итгэл-Эстимэйт” ХХК-ний №27/17 тоот Хөрөнгийн үнэлгээний тайлангаар тус дугуйнуудын нийт үнийг 561.1 сая төгрөгөөр тодорхойлсон боловч үнэ цэнийн бууралт бүртгээгүй байна.

Энэ нь НББОУС 36: Хөрөнгийн үнэ цэнийн бууралт-д заасан заалтуудтай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар дээрх асуудлын талаар зөвлөмж хүргүүлэв.

## **2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс 2016 оны 12 дугаар сарын 31 хүртэлх хугацааны санхүүгийн тайланд татварын шалгалт хийгдэж 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр татварын улсын байцаагчийн 210022565 дугаартай акт гарч 11,301.3 сая төгрөгийн төлбөрийг “Эрдэнэс таван толгой” ХК нь татварт төлөхөөр заажээ. Компанийн удирдлага тухайн актыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа ба Татварын ерөнхий газрын дэргэдэх татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан байна.
- 2017 оны байдлаар ЗЦ.АБХМатериал дансанд бүртгэлтэй 691.7 сая төгрөгийн ашиглалтад байгаа хангамжийн материал байна. Эдгээр материал нь ихэвчлэн 3 жилээс дээш хугацаанд ашиглагдсан бөгөөд одоог хүртэл үнэ цэнийн бууралтын тохируулга хийгдээгүй байна.

## **2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД**

Дүгнэлтийн хязгаарлалтын үндэслэл болон 2017 оны санхүүгийн аудитаар өгөгдсөн залруулагдаагүй алдааны зөвлөмжүүдийг хөөн шалгах шаардлагатай.

## **2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 11,400,840.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 11,353,425.5 сая төгрөгийн алдааг залруулж, 47,415.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 7 зөвлөмж өгсөн болно.


## **2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6 зөвлөмж өгсөн байна. Үүнээс 2 зөвлөмж хэрэгжсэн, 4 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

## **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 0.5 хувиар тооцож 3,271.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



## 2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Эрдэнэс таван толгой” ХК-ний нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



### 3.1 Хувьцааны бүртгэлийн талаар

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

“Эрдэнэс монгол” ХХК болон түүний охин компани талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2017 оны 5-р сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын 8.2-ыг үндэслэн, “Эрдэнэс монгол” ХХК-ийн ТУЗ-ын 2018 оны 03 сарын 14-ний өдрийн удирдамж, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ТУЗ-ын 2018 оны 03 сарын 01-ний өдрийн 01 дүгээр тушаалыг үндэслэн компани хувьцаагаа бүртгэсэн. Засгийн газрын 2017 оны 5-р сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын 8.2-т нэгж хувьцааг 933 төгрөгөөр үнэлж бүртгэхийг заасан байна. Бид нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 933 төгрөг байна гэсэн анхны тооцоолол, түүнийг нотлох баримтыг олж авч чадаагүй.

#### ҮАГ-ын зөвлөмж

- Ордын техник эдийн засгийн үндэслэлийг дахин боловсруулах
- Бизнес төлөвлөгөө боловсруулах
- Биет ба биет бус хөрөнгийн үнэлгээ,
- Бизнесийн үнэлгээ хийлгэх зэрэг ажлуудыг шат дараалалтайгаар хийж гүйцэтгүүлэн ашигт малтмалын лицензүүдийн зах зээлийн үнэлгээг гаргуулна. Энэхүү тооцоололд суурилан хувьцааны нэрлэсэн үнийг дахин тооцоолж залруулга хийх шаардлагатай гэж үзэж байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

#### Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд биет бус хөрөнгийн үнэ цэнэ буруу илэрхийлэгдсэн байх.

#### Гүйцэтгэх удирдлагын хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**3.2 Хөрс хуулалтын хөрөнгө ба түүний  
ХОРОГДУУЛАЛТЫН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**ҮАГ-ын ажиглалт**

Тайлант үед олборлосон нүүрсний тоон хэмжээг ТЭЗҮ дэх тухайн үеийн ашиглалтын үе дэх хөрс хуулалтын коэффициентээр үржиж тайлант үеийн өртөгт шингэх хөрс хуулалтын тоон хэмжээг гаргадаг. Зарим сард хөрс хуулалтын бодит хэмжээ тооцоолсон хэмжээнээс илүү гардаг. Энэ тохиолдолд илүү гарсан хэмжээг тайлант үеийн нэгжийн өртгөөр үржиж хөрс хуулалтын хөрөнгийг үүсгэдэг. Зарим сард хөрс хуулалт нь тооцоологдсон буюу хэмжээндээ хүрдэггүй байна. Энэ тохиолдолд тооцоолсон хэмжээнд хүртэл хөрс хуулалтын хэмжээг нэмэгдүүлж авдаггүй байна.

- Хөрс хуулалт тооцоолол их бага гарснаас үл хамааран хуримтлагдсан хөрс хуулалтын хөрөнгийг элэгдүүлж олборлосон нүүрсний өртөгт шингээдэг.
- Хөрс хуулалтын хөрөнгө данс нь мөнгөн дүнгээрээ л санхүүгийн програмд бүртгэгдэж байна. Хөрс хуулалт дансыг биет хэлбэрээр буюу куб.метр-ээр, мөн ашиглалтын үеэр ангилан бүртгэгдэггүй байна.
- Хөрс хуулалтын хөрөнгө болон түүний хөдөлгөөн үлдэгдлийн тайланд уулын хэлтэс ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээдэггүй зөвхөн нягтлан бодогч эхсел дээр суурилсан тооцоон дээрээ үндэслэн бичилт хийдэг.

**ҮАГ-ын зөвлөмж**

Санхүүгийн хэлтэс, уулын хэлтэс, бүртгэлийн хэлтэс хамтран хөрс хуулалтын хөрөнгийн элэгдүүлэлтийг хэрхэн хийх талаар аргачлал гаргаж түүнийгээ гүйцэтгэх удирдлагаар батлуулан мөрдөх, уулын хэлтэс хөрс хуулалтын хөрөнгө дансны бүртгэх дүнг уулын ажлын тайлан шиг гаргаж өгдөг байхаар шийдэх нь зүйтэй гэж үзэж байна. Ингэж чадвал хөрс хуулалтын хөрөнгө дансны бүртгэл үнэн зөв болох ба баланс дээр байгаа данс хариуцах эзэнтэй болно.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Эрсдэлүүд**

Олборлолтод шингэх хөрс хуулалтын зардал тайлант хугацаануудад тэр тусмаа ашиглалтын нэг үеийн сар бүр өөр өөр хувиар шингэж байна. Нэг үгээр хэлбэл хөрс хуулалтын зардал ашиглалтын нэг үед бүтээгдэхүүний өртөгт нэг ижил хувиар шингэхгүй өөр өөр хувиар шингэж байна. Хөрс хуулалтын хөрөнгө дансны бүртгэл бүрхэг, тоон мэдээллийг харах боломжгүй болсон байна. Үүнээс шалтгаалан хөрс хуулалтын хөрөнгө дансны үлдэгдэл нь хэзээ хорогдож дуусах вэ?, хэдий хэмжээний олборлолтод ногдох хөрс хуулалт байгаа вэ? гэдэг мэдээллийг харах боломжгүй болсон байна.

**Гүйцэтгэх удирдлагын хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**3.3 Нөхөн сэргээлт-хаалтын хөрөнгө ба түүний хорогдуулалтын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**ҮАГ-ын ажиглалт**

Нөхөн сэргээлт-хаалтын хөрөнгө данс нь борлуулалтын нэг хувиар жил бүр нэмэгдэж бүртгэгддэг. Энэ дансыг нэмэгдүүлж байгаа дүнгийн суурь тооцооллыг өмнөх аудитын компаниуд үнэн зөв гэж үзэх үндэслэл муутай гэж үзсэн ба энэ утгаараа аудиторын дүгнэлтийг хязгаарлах нэг үндэслэл болгож байсан байна. Бид бүхэн мөн энэ тооцооллыг үнэн зөв гэж үзэхгүй байгаа болно.

Энэ дансны хорогдуулалтыг тооцоолохдоо: Жил бүрийн орлогоор нэмэгдэж байгаа дүнг цанхийн уурхайн цаашид ажиллахаар төлөвлөгдөж байгаа жилд хувааж хорогдуулж байна. Энэ тооцооллоор хорогдуулбал дараагийн жилүүдэд энэ хөрөнгийн хорогдуулах дүн ихэссээр маш их болохоор тооцоологдож байна. Үүнээс шалтгаалан энэ тооцооллыг бид мөн л үнэн зөв гэж үзэхгүй байна. Өөрөөр хэлбэл тайлант жилүүдэд эсвэл олборлолтын тонн тутамд жигд хуваарилагдахгүй байна гэж үзэж байна.

Энэ нь НББОУС 37: Болзошгүй өр төлбөр ба Болзошгүй Хөрөнгө-д заасан заалтуудтай зөрчилдөж байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Нөхөн сэргээлт-хаалтын хөрөнгө дансны үнэлгээг хийхдээ элэгдүүлэлтийг нь мөн давхар шийдэх шаардлагатайг анхаарч ажиллах хэрэгтэй.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Эрсдэлүүд**

Нөхөн сэргээлт-хаалтын хөрөнгө ба түүний хорогдуулалтыг буруу тайлагнаснаар санхүүгийн тайлан хэрэглэгчидийг алдаатай мэдээллээр хангана.

**Гүйцэтгэх удирдлагын хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.4 Уурхайн үйл ажиллагаанд ашигладаг MINEX, MICROMINE ПРОГРАМЫН ХОРОГДУУЛАЛТЫН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №4**

**ҮАГ-ын ажиглалт**

2017 онд Minex програмыг уурхайн үйл ажиллагаанд ашиглахаар 1,050.0 сая төгрөгөөр худалдан авсан байна. Тус програмыг 3 жил ашиглана гэж Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.6.7-д тусгасаны дагуу хорогдуулж бүртгэсэн. Энэ нь хэт богино хугацаа гэж үзэж байна. Мөн Micromine програмыг 2014 онд авсан ба одоог хүртэл ашиглаж байгаа.

Энэ нь НББОУС 38: Биет бус хөрөнгө-д заасан 98-р заалттай зөрчилдөж байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

НББ-ийн бодлогоор биет бус хөрөнгийг 3 жил элэгдүүлнэ гэж заасан байгаад өөрчлөлт оруулах тал дээр судалгаа хийх, хэрвээ ажиглах жил нь тодорхой бол ашиглагдахаар төлөвлөгдөж байгаа жилд нь элэгдүүлнэ гэж оруулж өгөх хэрэгтэй.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Эрсдэлүүд**

Micromine програмыг мөн 3 жилээр элэгдүүлж дууссан боловч одоог хүртэл ашигласаар байгаа ба цаашид ч ашиглахаар байна. Өртөг нь 3 жилд хорогдоод дууссан байна. Хэтэрхий богино хугацаанд элэгдүүлснээр 2 програмыг хорогдуулалт өртөгт богино хугацаанд хэт өндрөөр нөлөөлж байна.

**Гүйцэтгэх удирдлагын хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.5 НҮҮРСНИЙ ОВООЛГЫН БҮРТГЭЛ, ҮЛДЭГДЛИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №5**

**ҮАГ-ын ажиглалт**

- Бараа материал хариуцсан нягтлан бодогч нүүрсний ачилтыг харилцагч бүрээр сард нэг удаа бичилт хийж санхүүгийн програмд оруулдаг. Энэ нь хэтэрхий хураангуйлсан шинжтэй байна. Нүүрсний ачилтыг ачааны машинд ачилт хийгдэх бүрдээ санхүүгийн програмд бүртгэх шаардлагатай байна.
- Нүүрсний ачилтын бичилт хийгдэх бүрд худалдан авагчаас авах авлага нэмэгдэх буюу урьдчилж төлсөн төлбөр нь буурах бичилт програмаас хийгддэг байхаар бүртгэлийн үйл ажиллагаагаа зохицуулаагүй буюу борлуулалтын нягтлан бодогч борлуулалтын авлагыг журналаар хийж байна.
- Нүүрсийг бүртгэлд зүүний исэлдсэн болон коксожсон, барууны исэлдсэн болон коксожсон гэсэн дөрвөн ангиллаар бүртгэсэн байна. Харин уурхай дээр нүүрсийг баруун, зүүн цанхиар нь хуваахын зэрэгцээ овоолгоор бүртгэж байна. Бүртгэл ч мөн үүнтэй адил овоолгоор бүртгэх шаардлагатай байна.
- Нүүрсийг олборлогч нараас авахдаа куб.метрээр тооцоолж авдаг, бүртгэлд тусгахдаа тоннд шилжүүдэг. Худалдан авагч нарт зарахдаа тонноор хэмждэг. Сар бүрийн үлдэгдлийг маркшэйдрийн хэмжилтээр авдаг. Маркшэйдрийн хэмжилт нь куб.метрт суурилдаг. Үүнээс харахад нягтлан бодох бүртгэл дэх нүүрсний үлдэгдэлд тооллогын, үлдэгдлийн зөрүү бага боловч дүнгээр байнга гарахаар харагдаж байна. Гэтэл бүртгэлд ийм залруулга байхгүй байна. Маркшэйдрүүдтэй уулзаж асуухад овоолго дуусах бүрд дээрх зөрүү гардаг энэ тохиолдолд акт үйлдэж үлдэгдлийн зөрүүг тодорхойлдог. Зөрүүгээ дараагийн сарын уулын ажлын тайландаа оруулдаг гэж тайлбарлаж байна. Энэ тохиолдолд тухайн овоолго хаагдсан сарын хөрс хуулалтын хэмжээ, үүнийг дагаад үнийн дүн буурч бодит тоон мэдээлэлд нөлөө орж байна. 2017 онд нийт 32 овоолго нээгдээд хаагдсан зөрүү нь 239,406 тонн. 2017 онд нээгдээд 2018 оны 3 дугаар сарын 01-ний байдлаар хаагдсан овоолго 7, зөрүү нь 90,825 тонн, 2017 онд нээгдээд 2018 оны 3 дугаар сарын 01-ний байдлаар хаагдаагүй байгаа овоолго 14, зөрүү нь ойролцоогоор 139,583 тонн байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Дээрх асуудлуудыг үүсгэхгүй байхаар бүртгэлийн бодлогодоо нийцүүлсэн журам боловсруулж батлуулах түүнийгээ мөрдөх, Нүүрс орлогод авахдаа эхлээд нэгтгэл данс руу бүх зардлаа хаах дараа нь тусдаа бичилтээр нүүрсийг орлогод авах нь зүйтэй байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



- Нүүрс орлогод авч байгаа дансны бичилт хэтэрхий хураангуйлсан шинжтэй байна. Үүнээс шалтгаалан ойлгомж муутай, хяналт тавихад хүндрэлтэй болсон байна.

### **Эрсдэлүүд**

Эхний 2 асуудлаас шалтгаалан санхүүгийн тайланд алдаа гарах магадлал нэмэгдэнэ. 3-р асуудлаас шалтгаалан эдийн засагч, төлөвлөлтийн хэлтсийн ажилтнууд санхүүгийн тайландаа шинжилгээ хийх, удирдлага санхүүгийн тайлангаас тоон мэдээ харах боломж хумигдана. Мөн нүүрсний үлдэгдэл үнэн зөв гарах боломжийг хааж байна. Жишээлбэл овоолго хаах бүрд санхүүгийн тайланд залруулга хийх бодит шаардлага гарахгүй байна. 4-р асуудлаас шалтгаалан уулын ажлын тайлан, санхүүгийн тайлан материаллаг хэмжээгээр буруу илэрхийлэгдсэн байна.

### **Гүйцэтгэх удирдлагын хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.6 МАРГААНТАЙ ӨГЛӨГИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №6**

**ҮАГ-ын ажиглалт**

“Говь повер” ХХК-тай холбоотой асуудлаар шүүх хурал явагдсаар байна. “Говь повер” ХХК-иас хүлээн авсан зарим хөрөнгийг компани ашиглаж байгаа, заримыг нь акталж устгасан, зарим нь ашиглагдах боломжгүйгээр эвдэрсэн байдалтай байгаа юм байна. Одоогийн байдлаар газар эзэмших эрх болон байгууламжууд нь ашиглагдаагүй байна. Анхан шатны шүүхээр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн талд гарсан байна. Дараагийн шатны шүүхээс нөгөө талд шүүхийн шийдвэр гарч шүүгдэгч суллагдсан байна. Эндээс харахад байдал хаашаа ч эргэх магадлалтай байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

“Говь повер” ХХК-ийн хувьд ашиглалт муутай өгөөж өгөхгүй эдгээр хөрөнгийг бүртгэлд элэгдүүлсээр байна. Иймд эдгээр хөрөнгийг хэрхэн ашиглах цаашид ямар арга хэмжээ авах талаар ТУЗ-ийн шийдвэр гаргуулж түүнийгээ мөрдөх шаардлагатай байна. Ашиглахаар бол яг энэ үед бусдын нүүрсийн буулгаж түрээс олох боломж байна, цаашид ашиглахгүй буцааж өгөх гэж байгаа бол бусдын хөрөнгийг эвдлэн сүйтгэх, тонох зэрэг асуудал гаргахгүйгээр ямар хөрөнгө хүлээж авсан тэр хэвээр нь байлгахыг хичээх хэрэгтэй байна. Шүүгдэгч мөнгөө төлж хохиролгой болгох л юм бол ямар хөрөнгө өгсөн түүнийгээ нэхэмжилж авах нь эргэлзээгүй гэж бодож байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Эрсдэлүүд**

Үүссэн асуудлуудыг шийдэж байгаа хугацаа маш удаан байна. Ингэснээр өр төлбөрүүд нь тухайн үеийнхээ санхүүгийн үр дүнд нөлөөлж чадахгүй өнгөрч байна. Дээрх асуудлуудын 1-ээс бусад нь татварын зардлыг өсгөхөд нөлөөлсөн байна.

**Гүйцэтгэх удирдлагын хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**3.7 Ашиглагдахгүй байгаа, ашиглалт муутай  
ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №7**

**ҮАГ-ын ажиглалт**

- Нөхөн TAS 3600 маркийн 10 ширхэг машин ашиглагдахгүй байгаа боловч тухайн хөрөнгийг элэгдүүлж өртгийг хий нэмэгдүүлсэн байна. Дахин үнэлгээ хийлгэсэн байна.
- Ашиглагдахгүй байгаа Magna маркийн 26 дугуй нийт 3,186.3 сая, Махат маркийн 18 дугуй нийт 225.3 сая, нийт 3,411.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан анхны өртгөөрөө балансад эргэлтийн хөрөнгөөр бүртгэгдсэн байна. 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн “Итгэл-Эстимэйт” ХХК-ний №27/17 тоот Хөрөнгийн үнэлгээний тайлангаар тус дугуйнуудын нийт үнийг 561.1 сая төгрөгөөр тодорхойлсон боловч үнэ цэнийн бууралт бүртгээгүй байна.

Энэ нь НББОУС 36: Хөрөнгийн үнэ цэнийн бууралт-д заасан заалтуудтай зөрчилдөж байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Дахин үнэлгээ хийлгэж, ТУЗ зарж борлуулах эрхийг нь өгсөн байна. Иймд “Эрдэнэс Монгол” ХХК болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийг гаргуулан авч асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна. Арга хэмжээ авахгүй удах тусам дээрх хөрөнгүүдийн үнэ цэнэ унаж байгууллагын хүлээх алдагдал нэмэгдсээр байх болно.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд ашиглагдахгүй байгаа, чанар байдал муутай хөрөнгөд тусгай бодлого ашиглахгүй байснаас санхүүгийн тайланг хэрэглэгчдийн шийдвэрт сөргөөр нөлөөлөх магадлалтай ба санхүүгийн тайлагнал буруу байх эрсдэлтэй байна.

**Гүйцэтгэх удирдлагын хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



#### 4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	2016	2017
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	41,526,484,799.90	88,401,226,493.82
Дансны авлага	20,086,703,339.63	24,184,390,200.38
Татвар, НДШ-ийн авлага	1,872,554,595.45	10,213,420,382.41
Бусад авлага	393,021,092.96	418,067,128.41
Бусад санхүүгийн хөрөнгө	-	6,591,680,454.00
Бараа материал	66,187,970,167.65	178,218,101,026.34
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,570,446,835.25	6,607,844,825.21
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>138,637,180,830.84</b>	<b>314,634,730,510.57</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	24,088,499,831.64	20,238,312,632.12
Биет бус хөрөнгө	3,539,320,797.66	11,194,157,138,474.20
Урт хугацаат хөрөнгө оруулалт	597,320,898.92	583,351,666.14
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	1,224,662,866.73
Хойшлогдсон татварын хөрөнгө	28,850,746,779.40	10,909,550,573.93
Бусад эргэлтийн бус хөрөнгө	283,999,670,130.10	304,790,483,979.50
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>341,075,558,437.72</b>	<b>11,531,903,500,192.60</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>479,712,739,268.56</b>	<b>11,846,538,230,703.20</b>

##### ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

###### Өр төлбөр

###### Богино хугацаат өр төлбөр


Дансны өглөг	216,472,613,183.44	80,205,950,213.53
Цалингийн өглөг	1,700,409,774.12	955,813,925.63
Татварын өр	1,539,586,031.68	14,428,701,269.15
НДШ-ийн өглөг	113,639,739.46	34,011,766.24
Богино хугацаат зээл	-	121,356,500,000.00
Хүүний өглөг	95,895,758,491.12	94,104,196,555.41
Урьдчилж орсон орлого	62,363,012,668.61	149,467,471,535.31
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>378,085,019,888.43</b>	<b>460,552,645,265.27</b>

###### Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат зээл	497,906,000,000.00	121,356,500,000.00
Нөөц /өр төлбөр/	19,984,844,850.44	31,808,479,597.23
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>517,890,844,850.44</b>	<b>153,164,979,597.23</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>895,975,864,738.87</b>	<b>613,717,624,862.50</b>

###### Эздийн өмч

Төрийн өмч	300,000,000.00	-
Хувьцаат өмч	-	11,196,000,000,000.00
Хуримтлагдсан ашиг	(416,563,125,470.31)	36,820,605,840.75
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(416,263,125,470.31)</b>	<b>11,232,820,605,840.75</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>479,712,739,268.56</b>	<b>11,846,538,230,703.20</b>



#### 4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	2016	2017
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	467,131,660,701.93	1,182,364,018,363.60
Борлуулалтын өртөг	373,265,062,332.44	381,175,581,819.66
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>93,866,598,369.49</b>	<b>801,188,436,543.94</b>
Хүүний орлого	365,499,148.22	1,946,557,445.36
Бусад орлого	18,546,646,742.59	9,692,101,883.74
Борлуулалт, маркетингийн зардал	70,527,194,345.84	159,872,978,998.43
Ерөнхий ба удирдлагын зардал	6,184,666,719.25	10,832,332,780.13
Санхүүгийн зардал	54,400,484,141.48	39,521,255,700.26
Бусад зардал	10,405,287,415.00	16,870,872,565.65
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(184,635,064,876.78)	(31,088,317,451.06)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(32,628,196.45)	(30,113,794.14)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(213,406,581,434.50)</b>	<b>554,611,224,583.37</b>
Орлогын татварын зардал	(14,566,291,495.96)	93,541,814,887.27
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(198,840,289,938.54)</b>	<b>461,069,409,696.10</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Өмч	Халаасны хувьцаа	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>300,000,000.00</b>	-	<b>(193,119,980,586.02)</b>	<b>(192,819,980,586.02)</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(24,602,854,945.75)	<b>(24,602,854,945.75)</b>
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	(198,840,289,938.54)	<b>(198,840,289,938.54)</b>
<b>2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>300,000,000.00</b>	-	<b>(416,563,125,470.31)</b>	<b>(416,263,125,470.31)</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(7,685,678,385.04)	<b>(7,685,678,385.04)</b>
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	461,069,409,696.10	<b>461,069,409,696.10</b>
Өмчид гарсан өөрчлөлт	(300,000,000.00)	11,196,000,000,000.00	-	-
<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>11,196,000,000,000.00</b>	<b>36,820,605,840.75</b>	<b>11,232,820,605,840.70</b>



#### 4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөгөөр/	
	2016	2017
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>93,159,832,766.62</b>	<b>1,000,260,077,004.32</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	77,832,868,981.42	925,983,243,668.65
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	93,833,983.00	123,698,863.00
Бусад мөнгөн орлого	15,233,129,802.20	74,153,134,472.67
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(46,814,241,627.06)</b>	<b>(705,405,549,985.43)</b>
Ажиллагчдад төлсөн	(13,299,696,384.28)	(17,114,201,908.76)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(3,320,000,000.00)	(4,260,372,065.00)
Бараа материал худалдан авахад төлсөн	(655,381,379.33)	(911,300,286.48)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(1,253,422,016.46)	(1,257,277,345.88)
Хүүний төлбөрт төлсөн	(2,407,292,583.14)	(34,923,052,744.75)
Татварын байгууллагад төлсөн	(1,847,820,728.78)	(213,888,213,955.59)
Даатгалын төлбөрт төлсөн	(162,997,184.25)	(88,982,417.26)
Бусад мөнгөн зарлага	(23,867,631,350.82)	(432,962,149,261.71)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>46,345,591,139.56</b>	<b>294,854,527,018.89</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(1,427,898,357.50)</b>	<b>(2,358,785,325.00)</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(91,288,490.00)	(841,273,057.50)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(516,238,467.50)	(1,517,512,267.50)
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(20,371,400.00)	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(800,000,000.00)	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,427,898,357.50)</b>	<b>(2,358,785,325.00)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(10,524,787,631.37)</b>	<b>(245,621,000,000.00)</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(10,524,787,631.37)	(245,621,000,000.00)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(10,524,787,631.37)</b>	<b>(245,621,000,000.00)</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>34,392,905,150.69</b>	<b>46,874,741,693.89</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>7,133,579,649.21</b>	<b>41,526,484,799.90</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>41,526,484,799.90</b>	<b>88,401,226,493.82</b>



15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

